

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газрын  
2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2024/130/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Дорноговь аймаг  
2024 он

Тэргүүлэх аудитор:	Т.Ган-Өлзий
Утас: 70522734	Цахим хаяг: gan-ulziit@audit.gov.mn
Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
Багийн ахлагч аудитор:	О.Нарангарав
	Цахим хаяг: narangarav.o@audit.gov.mn
Аудитор:	Д.Дэмбэрэлсүрэн
	Цахим хаяг: Munkhnasann@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аudit бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд төрийн санхүү, төсөв, нийтийн өмчтэй холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний акт, бусад эрхзүйн актын хүрээнд нийтийн өмчийг төлөвлөх, хуваарилах, ашиглах, зарцуулах үйл ажиллагааны арвилан хэмнэлт, үр ашигтай, үр нөлөөтэй байдал болон төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аudit хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай байгууллагын үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Эргэлтийн бус хөрөнгөтэй холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 31 нэр төрлийн 206,059.6 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1-д "...ашиглах хугацаа нь дууссан эд хөрөнгийг... акт тогтоон устгаж болно", 31.3.2-т "...элэгдэл хорогдлын шимтгэлээрээ анхны үнийг нь нөхсөн ... эд хөрөнгийн үнийг ...зөвшилцөн тогтооно" гэж заасныг зөрчсөн байна.

1.2 Үр дагавар:

1.2. Өгсөн зөвлөмж: Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн ашиглагдахгүй хөрөнгийг акталж данснаас хасах байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хөрөнгийг дахин шинээр үнэ тогтоох асуудлыг шийдвэрлэх.

## 2. Шилэн данстай холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт: Тайлант онд байгууллагын шилэнд дансны системд 1,645,397.8 мянган төгрөгийн 57 мэдээллийг хугацаа хоцроож, 617,404.5 мянган төгрөгийн 46 мэдээллийг байршиулаагүйгээс шилэнд дансанд мэдээг мэдээлсэн байдлын хэрэгжилт 78.5 хувь, хугацаа хоцролтын хэрэгжилт 61.2 хувьтай байна.

Энэ нь шилэн дансны тухай хуулийн

2.2 Үр дагавар:

2.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

### МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

#### ХЯНАСАН:

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

АУДИТЫН МЕНЕЖЕР

У.ОЮУНТҮЛХҮҮР

#### БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Н.МӨНХНАСАН



Майч



## ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР АКТ

2024 оны 03 сарын 06 өдөр

Дугаар 20/Д/071227  
ДГА - 2024/130/НА-СТА-7Ш3

Сайншанд сум

### Төлбөрийг барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Дорноговь аймгийн Биеийн тамир спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шалгагдагч байгууллагын хүний нөөцийн мэргэжилтэнд Э.Оюунсүрэн нь архив, бичиг хэргийн ажилтныг TY-4 албан тушаалын цалингийн 40 хувиар хавсрان гүйцэтгэхээр тогтоосон. Гэвч тус нэмэгдлийг үндсэн ажлын цалингаас тооцоолж, нийт 53,100 төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.1.3-т “гүйцэтгэсэн ажил үүрэгтээ тохирсон цалин хөлс авах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т “Шалгагдагч этгээд төсөөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, МУЫН Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.3.3-т заасныг үндэслэн ТОГТООХ нь:

- Илүү олгосон цалин болох нийт 53,100 (тавин гурван мянга нэг зуун) төгрөгийг төлүүлж, Төрийн сан дахь орон нутгийн орлогын 100060000955 тоот дансанд төвлөрүүлэх,
- Төлбөрийн актын биелэлтийг 2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг Биеийн тамир, спортын газрын дарга (Г.Батлхам), нягтлан бодогч (Д.Болормаа) нарт даалгав.

### ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ

Н.МӨНХНАСАН



010050009

  
ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТИН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 07 өдөр

Дугаар 48/А1071222

Сайншанд сум

ДРА-2024/130/НА-СТАТШ З

Г  
Зөрчил давтан гаргахгүй байх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газар 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Шалгагдагч байгууллага нь аудитад хамрагдсан хугацаанд эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй, байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2.1-т “Үндсэн хөрөнгө, дуусаагүй хөрөнгө оруулалт ба барилга угсралтын ажил, их засварын” зардлын тооллогыг жилд нэг удаа /12 дугаар сарын 01-нээс 31-ний дотор/ 70.2.2-т “Түүхий эд, материал, түлш, сэлбэг хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, бараа, сав, баглаа боодлын” тооллогыг жилд 2 удаа / 6 дугаар сарын 1, 12 дугаар сарын 1-нээс 31-ний / дотор тооллогыг явуулж улирал, жилийн тайлан тэнцэлд тусгаж тайлagnана”, гэж заасныг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, МУ-ын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.2-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь**:

1. Эд хөрөнгийн тооллогыг хууль тогтоомжийн дагуу гүйцэтгэж, албан шаардлагын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн дотор Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх,

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Дорноговь аймгийн Биеийн тамир, спортын газрын дарга (Г.Батлхам), нягтлан бодогч (Д.Болормаа) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТОР

Т.ГАН-ӨЛЗИЙ  
Н.МОНХНАСАН

010040161